

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 02 дугаар сарын 07-ны өдөр

№ 22/01

Улаанбаатар хот

**Компанийн 2021 оны санхүүгийн болон
үйл ажиллагааны тайлангийн
талаар дүгнэлт батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дахь заалт, 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.16 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит хурлаас гарсан дүгнэлт, Компанийн ТУЗ-ийн 2022 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон, СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд “Эрнст энд Янг Монголиа Аудит” ХХК-ийн гаргасан аудиторын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.
3. Энэхүү тогтоолын 2-т заасан тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж зохих шийдвэрийг гаргуулахыг ТУЗ-ийн Дарга /О.Болдбаатар/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга /Ж.Жаргалсүрэн/-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 02 дугаар сарын 07-ны өдөр

№ 22/02

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын 2021 оны гүйцэтгэлийн үр дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 81 дугаар зүйлийн 81.5.4 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9.6.9 дэх заалт, Компанийн Гүйцэтгэх захиралтай байгуулсан Хөдөлмөрийн контракт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны 2022 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн ЗХ-22/01 тоот дүгнэлт, санал, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Бүлтэн овогтой Удвалын 2021 оны ажлын гүйцэтгэлийг үр дүнг үнэлж, түүнд олгох урамшууллыг тогтоолын хавсралтаар баталсугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 02 дугаар сарын 07-ны өдөр

№ 22/03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 23 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) -ийн үйл ажиллагааны журмын 2.8.8 дахь заалт, Ногдол ашгийн бодлогын 2.2 дахь заалт, Компанийн ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2021 оны жилийн эцсийн цэвэр ашигаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 1.50 /нэг төгрөг тавин мөнгө/ төгрөгөөр тогтоож, 2021 оны цэвэр ашгаас 27.5 хувийг буюу 1,108,952,525.50 (нэг тэрбум нэг зуун найман сая есөн зуун тавин хоёр мянга таван зуун хорин таван төгрөг тавин мөнгө) -ийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашигаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2022 оны 04 дүгээр сарын 30-ны дотор олгосугай.
4. Ногдол ашиг хуваарилж, олгох тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашигийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

ЛЭНДМН ББСБ ХК

О.БОЛДБААТАР

УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎ 1118267206

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 02 дугаар сарын 07-ны өдөр

№ 22/04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх хэсэг, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2 дугаар бүлгийн 2.1, 2.3, 2.5 дахь хэсэг, 3 дугаар бүлэг, 4 дүгээр бүлгийн 4.1, 4.1.2, 4.2.1, 4.3 дахь хэсэг Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 12 сарын 22-ны өдрийн 385 тоот тогтоол, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 болон 8.2 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ГУЗ”)-ийн 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурлыг 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 12:00 цагт цахим хэлбэрээр буюу хувьцаа эзэмшигчдийг нэг дор олноор цуглуулахгүй байдлаар зохион байгуулж, Компанийн Фэйсбүүк хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд шууд дамжуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай:
 - 2.1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
 - 2.2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 2.3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
 - 2.4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 5 гишүүдийг улируулан сонгох;
 - 2.5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 4 гишүүдийг шинээр сонгох;
 - 2.6. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсвийг батлах.
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталж, “Санхүүгийн зохицуулах хороо” болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн дотор хүргүүлэхийг ГУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Ж.Мөнхцэцэг/-д үүрэг болгосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай зарыг энэхүү тогтоолын Хавсралт №2-ын дагуу баталж, 2022 оны 02 дугаар сарын 11 болон 28-ны өдрүүдэд Компанийн цахим хуудас, өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлэг түгээдэг радио, телевиз болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг энэхүү тогтоолын Хавсралт №3-ын дагуу баталж, баримт бичгийг 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн дотор бэлтгэн, 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлж танилцах бололцоогоор хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын Хавсралт №3-т заасан баримт бичгийг 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хүртэл Компанийн www.Lend.mn вэбсайтруу орж танилцаж болохыг мэдэгдсүгэй.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Компанийн Гүйцэтгэх захирал /Б.Удвал/-ыг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн дараах ажилтны бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

М.Түвшинжаргал Санхүү, үйл ажиллагааны газрын захирал

Гишүүд:

Э.Батжаргал Бизнес хөгжлийн газрын захирал
 Ц.Ундрах Бүтээгдэхүүн хөгжлийн мэргэжилтэн
 Т.Од Дэд захирал, АНД Системс Тех ХХК
 Б.Хулан Хуулийн мэргэжилтэн
 Б.Батбилэг Маркетингийн менежер
 О.Батзаяа Харилцагчийн үйлчилгээний хэлтсийн менежер
 Э.Эрэлхэгзориг Мэдээллийн технологийн ахлах инженер
 О.Нарангарав Оффис менежер
 Ж.Мөнхцэцэг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

С.Батбуян “ЭмДиЭс Хаан Лекс” ХХН, Партнер

Гишүүд:

Х.Одончимэг Хууль, хянан нийцүүлэлт хариуцсан мэргэжилтэн
 П.Урангоо Санхүүгийн шинжээч
 Ж.Булган Санхүүгийн шинжээч

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудасны дагуу санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг Хурлын дарга /Б.Удвал/-д үүрэг болгосугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг энэхүү тогтоолын Хавсралт №4-ийн дагуу, санал авах хуудсыг Хавсралт №5а, №5б, №5в-ын дагуу тус тус баталсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудсыг брокер, дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт санал авах ажлыг зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгож, тэдгээр саналын хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 18:00 цагаар тасалбар болгохоор тогтоосугай.
14. Компанийн энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчээс Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад оруулах саналыг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хүлээн авахыг ТУЗ-ийн

Нарийн бичгийн дарга /Ж.Мөнхцэцэг/, Хурал зохион байгуулах комиссын дарга /М.Түвшинжаргал/ нарт тус тус үүрэг болгосугай.

15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон гарах зардлын төсвийг баталж, санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Удвал/-д зөвшөөрсүгэй.
16. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Ж.Мөнхцэцэг/, Гүйцэтгэх захирал /Б.Удвал / нарт тус тус үүрэг болгосугай.

